

**ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ЯАМДААС ИРҮҮЛСЭН
САНАЛУУДЫН НЭГТГЭЛ**

		Ирүүлсэн санал	Тусгасан байдал, тайлбар
1.	Батлан Хамгаалах Яамны санал	Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.2-т “..., зэвсэгт хүчин, ...” гэсний өмнө “..., батлан хамгаалах, ...” гэж нэмэх;	Саналыг тусгав.
2.		Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.2-т “... даатгуулагчийг ...” гэснийг “... даатгуулагчийн ...” гэж өөрчлөх;	Саналыг тусгав.
3.	Эрчим Хүчний Яамны санал	Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт “Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахдаа анхдагч хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулна.” гэж заасан. Иймд Даатгалын зуучлалын тухай болон Жолоочийн даатгалын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахдаа анхдагч хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулах нь зүйтэй байна.	Саналыг тусгав.
4.	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамны санал	Жолоочийн даатгалын тухай хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу даатгалын суурь хураамжийг ялгамжтай тогтоож байгаа тул тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан үнэлгээний доод хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс биш даатгалын суурь хураамжийн хэмжээнээс тооцон олгодог байх саналтай байна.	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. 2024 оны 03 дугаар сард Сангийн сайд, Хууль зүй, Дотоод хэргийн сайд нарын хамтран баталсан “Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”-д даатгалын үнэлгээний хэмжээг тогтоохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулж тухай бүр тогтоодог

			зохицуулалтыг бий болгох шаардлагатай тухай тусгасан бөгөөд шинэчлэн тогтоогдсон тухайн жилдээ тогтмол байх зарчимтай. Харин хуулийн төслийн даатгалын үнэлгээнд ногдох даатгалын суурь хураамжийн хэмжээг автотээврийн хэрэгслийн ангиллаас хамааран тогтоохоор зохицуулсан.
5.	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам	Хуулийн төслийн 4.1.5-д “жолоочийн даатгалын үйл ажиллагааны зардлыг боломжит хамгийн бага түвшинд байлгах” гэж жолоочийн даатгалын зарчимд шинээр нэмсэн байна. Жолоочийн даатгалын үйл ажиллагааны зардалд ямар зардал орох нь тодорхойгүй байгааг анхаарах;	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Хуулийн төслийн 4-р зүйл нь жолоочийн даатгалын ерөнхий зарчмуудыг товч дурдсан бөгөөд олон улсад хэрэглэгддэг зарчим юм. Мөн хуулийн төслийн 13.2-т заасны дагуу даатгалын зуучлагчид олгох жолоочийн даатгалын шимтгэлийн дээд хязгаарыг Хороо тогтоож болохоор зохицуулсан.
6.		Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т жолоочийн даатгалын үнэлгээний доод хэмжээ нь “хөрөнгийн хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөг хүртэл” байхаар тусгажээ. Тээврийн хэрэгсэл нь зориулалтын хувьд өөр өөр төрөлтэй байдаг бөгөөд даатгалын хураамжийн хэмжээг тогтоохдоо автотээврийн хэрэгслийн зориулалт, төрөл, ангилал зэргийг харгалзан тооцох зохицуулалтыг нэмэх саналтай байна.	Саналыг хэсэгчлэн тусгав. Хуулийн төслийн 10.1-т зааснаар даатгалын суурь хураамжийн хэмжээг Хороо автотээврийн хэрэгслийн ангиллаас хамааруулан тогтоохоор зохицуулагдан туссан болно. Харин тухайн даатгуулагчийн төлөх хураамж нь суурь хураамжаас бусад итгэлцүүрүүдээр үржүүлэгдэн бодогдож тооцогдоно.

7.		Жолоочийн даатгалын тухай хуулийн төслийн нэрийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-д “тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх” гэж заасантай нийцүүлэн “Тээврийн хэрэгсэл эзэмшигч (өмчлөгч)-ийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хууль” гэж өөрчлөх;	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд уг нэршлээр батлагдсан болно.
8.	Зам, Тээврийн хөгжлийн яам	Жолоочийн даатгалын тухай хуулийн төсөлд хуулийн зорилго нь хохирогчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор даатгалд хамруулна гэж заасан байх тул зорилго хэсгийг “Энэ хуулийн зорилго нь тээврийн хэрэгсэл эзэмшигчийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах, тэдний эрхийг хамгаалах, даатгалын үйлчилгээ (даатгалд цахимаар хамрагдах, мэдээлэл авах, өгөх, даатгалын тохиолдлын үеийн хохирлыг арилгуулах г.м)-г боловсронгуй болгох, замын хөдөлгөөнд оролцохдоо бусдын эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, арилгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж өөрчлөх найруулах; Жич: Хуулийн үндсэн агуулга, зорилтыг өргөжүүлэн сайжруулах шаардлагатай байхад зөвхөн “хохирогчийн эрх ашгийг хамгаалах хууль” болгон өөрчилсөн. Хуулийн үндсэн зорилго нь тээврийн хэрэгсэл эзэмшигчийг даатгалд хамруулах харилцааг тодорхой болгох, Даатгуулагчийн эрх ашгийг хэрхэн хамгаалах асуудал тусгагдаагүй байна. Энэхүү асуудлыг Санхүүгийн зохицуулах хороо хариуцахаар хуулийн төсөлд тусгагдсан боловч Хороо нь өнгөрсөн хугацаанд даатгуулагчийн эрх ашгийг хэрхэн хамгаалсан болохыг тандан судалгаанд тодорхой тусгаагүй байна.	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд уг нэршлээр батлагдсан бөгөөд зөвхөн хохирогчид учирсан хохирлыг даатгуулагчийн өмнөөс даатгагч барагдуулснаар мөн даатгуулагчийн эрх ашгийг хамгаалж байгаа тухай, мөн хуулийн төсөлд зөвхөн замын хөдөлгөөнөөс гадна авто зогсоол дээрх хөдөлгөөний улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөөр тусгагдсан болно.
9.		Хүчин төгөлдөр мөрдөж буй Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал даатгуулна” гэж, 5.3-д “Автотээврийн тухай хуулийн 3.1.15-д заасан тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч болон “С”, “D” ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолооч нь тээврийн хэрэгслийн өмчлөгч эсэхээс үл хамааран жолоочийн даатгалд заавал даатгуулна” гэж тус тус заасан хэдий ч	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. 2024 оны 03 дугаар сард Сангийн сайд болон Хууль зүй, Дотоод Хэргийн сайдын хамтран баталсан Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл

		тээврийн хэрэгсэл өмчлөгч, тухайн тээврийн хэрэгслийг жолоодож буй жолоочийг хариуцлагын даатгалд хамруулах зорилгоор бусад улс орнууд “Тээврийн хэрэгсэл эзэмшигчийн хариуцлагын албан журмын даатгал” гэж нэрлэж, даатгуулагчдын эрх ашгийг дээдэлсэн даатгалын эрх зүйн тогтолцоог нэвтрүүлэн ажилладаг. Гэтэл Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зөвхөн тээврийн хэрэгслийн өмчлөгчийг хариуцлагын даатгалд хамруулахаар тусгаж, ачаа болон зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж буй тухайн тээврийн хэрэгслийн өмчлөгч биш жолооч нарын асуудлыг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хасаж, зөвхөн тээврийн хэрэгсэл өмчлөгч нь ослын хохирлоо нөхүүлэхийн тулд жолоочийн даатгалд хамрагдана гэж томъёолсон байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-д “тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх” гэж заасантай нийцэхгүй байна.	баримтлалд “Автотээврийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15-д заасан тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч болон “С”, “D” ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолооч нь тээврийн хэрэгслийн өмчлөгч эсэхээс үл хамааран жолоочийн даатгалд заавал даатгуулна гэж заасан нь практикт “С”, “D” ангиллын тээврийн хэрэгслээр ажил, үйлчилгээ явуулдаг тээврийн хэрэгслийн өмчлөгчийн дийлэнх нь уг тээврийн хэрэгслийг жолоодох эрхтэй мэргэшсэн жолооч биш байдаг тул тухайн тээврийн хэрэгсэлд жолоочийн даатгалын 2 гэрээ байгуулах шаардлага тулгардаг. Олон улсын туршлагыг судлан үзэхэд, замын хөдөлгөөнд оролцож буй жолооч бүр заавал даатгуулах эсвэл авто тээврийн хэрэгслийн өмчлөгч нь даатгуулах зэрэг ялгаатай талууд байдаг. Иймд энэхүү жишиг туршлагад үндэслэн хуулийн зорилт, зарчмыг уялдуулж, нэг бодлого, зохицуулалтыг бий болгож, жолооч бүр даатгуулах эсхүл тээврийн хэрэгслийн өмчлөгч нь даатгуулах зохицуулалтын хувилбаруудыг тодорхой болгож
--	--	--	--

			өөрчлөх нь зүйтэй байна.” гэж заасан.
10.		Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д “Автотээврийн тухай хуулийн 3.1.15-д заасан тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч болон “С”, “D” ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолооч нь тээврийн хэрэгслийн өмчлөгч эсэхээс үл хамааран жолоочийн даатгалд заавал даатгуулна” гэсэн заалтыг практикт хүндрэлтэй байдаг мэтээр үндэслэлгүй дүгнэлт хийж хассан байх тул уг заалтыг хэвээр үлдээх шаардлагатай байна.	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Автотээврийн тухай хуулийн 3.1.15-д заасан тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч болон “С”, “D” ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолооч нь хураамж өндөр төлөх зохицуулалттай байгаа боловч даатгалын үнэлгээ бусадтай ижил байгаа нь шударга бус тогтолцоо тул уг заалтыг хассан болно.
11.		Жолоочийн даатгалын тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрд тандан судалгаа хийгээгүй, одоогийн мөрдөж буй хуулийн тодорхой чиг үүргүүдийг хассан байна. Тухайлбал одоогийн мөрдөгдөж буй хуулийн 10 дугаар зүйл (Даатгалын суурь хураамж), 11 дүгээр зүйл (даатгалын хураамж тооцох итгэлцүүр), Тавдугаар бүлэг (Жолоочийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт: 21 дүгээр зүйл, Жолоочийн даатгалын сан, 22 дугаар зүйл. Жолоочийн даатгалын сангийн бүрдүүлэлт, 23 дугаар зүйл. Жолоочийн даатгалын сангийн зарцуулалт)-ийг бүхэлд нь, Зургаадугаар бүлгийн 25 дугаар зүйл (Шуурхай алба)-ийг үндэслэл, тандалт судалгаагүйгээр хуулиас хассан байна. Жолоочийн даатгалын маш чухал бүлэг, зүйл, заалтуудыг үндэслэлгүйгээр хасаж, хуулийг дордуулсан байна. Хуулийн төсөлд Санхүүгийн Зохицуулах Хорооноос даатгалын суурь хураамжийн хэмжээг автотээврийн хэрэгслийн ангиллаас хамааруулан тогтоохоор заасан бөгөөд даатгалын суурь хураамж тооцох итгэлцүүрийг Хороо батлахаар заасан байна. Энэ нь даатгуулагчдын эрх ашигт харшлах тул Төрөөс хуулиар хэрэгжүүлдэг албан журмын даатгалыг УИХ-аас суурь хураамжийг тогтоож,	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Хуулийн төслийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгааг хийж боловсруулсан болно. Голлох итгэлцүүрүүд хуулийн төсөлд тусгагдсан байгаа ба итгэлцүүрүүд нь нэмэгдэх эсхүл хасагдах боломжтой байдлаар тусгасан. Учир нь технологийн дэвшил, эдийн засгийн хөгжил, санхүүгийн зах зээлийн хөгжлөөс хамаарч даатгалын эрсдэлд олон зүйлийн хамаарлууд нэмэгдэх чиг хандлагатай байгаа юм. Мөн даатгалын хураамжийн хэмжээг гаднын улс орнуудын сайн туршлагын дагуу эрсдэлийн түвшин, эдийн засгийн суурь

		итгэлцүүрээр өсгөж, бууруулан, итгэлцүүрийг тодорхой болгох нь зүйтэй байна.	үзүүлэлттэй уялдсан актуар тооцоололд үндэслэн уян хатан байдлаар тогтоодог байхаар тусгасан.
12.		Жолоочийн даатгалын тухай хуулийн төсөлд жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр авч бусдад хохирол учруулсан иргэн төлбөрийн чадваргүй болсон, эсхүл нас барсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар нарийвчилсан зохицуулалт тусгаагүй байгааг анхаарах;	Саналыг тусгав. Хуулийн төслийн 21.3 заалтад дараах байдлаар тусгав. “Энэ хуулийн 21.2-т заасан буруутай этгээд нас барсан эсхүл төлбөрийн чадваргүй болох нь шүүхээр тогтоогдсон бол Холбоо нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх эрх дуусгавар болно.”
13.		Жолоочийн даатгалын тухай хуулийн төсөлд даатгалын орлогыг юунд зарцуулах талаар тусгагдаагүй байх тул орлого зарцуулалтын зориулалтыг хуулийн төсөлд нарийвчлан тусгах шаардлагатай байна. (Жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлого нь нэг хэсгийн ашиг орлого олох хэрэгсэл байж болохгүй)	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Даатгагч нар нь даатгалын тухай хууль болон Хорооны холбогдох журмуудын дагуу эрсдэлийн нөөц сан үүсгэх, нөхөн төлбөр олгох гэх мэт харилцаанууд зохицуулагддаг.
14.		Жолоочийн даатгалын тухай хуулийн төсөлд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, энэ чиглэлээр тээврийн хэрэгслийн жолооч хариуцлагатай байхыг даатгалын тухай хуулийн төсөлд тусгах; Зам тээврийн ослын улмаас жил бүр 500 гаруй хүн амь насаа алдаж, 1000 гаруй хүн гэмтэж, бэртэж хөгжлийн бэрхшээлтэй болж байгааг хуулийн төслийн тандан судалгаанд огт дурдаагүй. Жолоочийн даатгал хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2012 оноос хойших хугацаанд энэ тоо огт буурахгүй, өссөөр байгаа нь одоогийн хуулийн төсөлд жолоочийг хариуцлагажуулах, ослын шалтгааныг судлан, түүнийг арилгах ажлууд хийгдэхгүй байгаатай холбон авч үзээгүй байна. Даатгалын хураамжийн орлогын тодорхой хэсэг ослын шалтгааныг арилгахад зориулагдах нь даатгуулагчдын эрх ашигт нийцнэ гэж үзэж байна.	Саналыг тусгав. Заавал даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй даатгагч нараас төвлөрүүлэх хураамжаас тодорхой хувийг даатгалын сургалт, сурталчилгаа явуулах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах талаар Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 65-д заасан Заавал даатгалын холбооны чиг үүрэгт тусгасан. Мөн тус хуулийн төслийн 15-р зүйлд даатгуулагч,

			жолоочийг үүрэгжүүлэн, хариуцлагажуулах тодорхой заалтууд туссан болно.
15.		Жолоочийн даатгалын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд "... автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн бусдын амь нас, эрүүл мэндэд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, даатгуулагч болон хохирогчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор автотээврийн хэрэгслийн өмчлөгчийг заавал даатгалд хамруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж заасан нь үндсэндээ зам тээврийн ослоос шалтгаалсан хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах үндсэн зорилтыг нарийвчлан тусгаагүй, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэгдэх чиг үүргийг орхигдуулсан, зам тээврийн ослыг бууруулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хэрхэн зохион байгуулахыг тодорхой тусгаагүй байх тул хуулийн төслийн зорилт хэсгийг тодорхой ойлгомжтой болгох;	Саналыг тусгав. Хуулийн төслийн 1-р зүйлд "... зам тээврийн ослын улмаас ..." гэж өөрчлөн найруулав.
16.		Жолоочийн даатгалын тухай хуулийн төсөлд зам тээврийн ослын хохирлыг нөхөн олгож байгаа одоогийн хүнд суртлыг хэрхэн арилгах, сайжруулах чиглэлээр холбогдох зүйл, заалт тусгагдаагүй байна. Даатгалын хураамжаас өнгөрсөн хугацаанд жилд дунджаар нөхөн төлбөрт 53 орчим хувийг төлсөн байна. Гэтэл хуулийн төсөлд энэ чиглэлийн асуудлыг шийдвэрлэх алхмууд тусгагдаагүй, өмнөх хуулиас дэвшил гараагүй байна. Тухайлбал, авто замын түгжрэлд нөлөөлж буй зам тээврийн ослын бүртгэлийг цахимаар хийгээд, ослын дараа жолооч шууд засварын газарт очиж, автомашинаа засуулаад гардаг үйлчилгээнд шилжих ёстой байтал энэ асуудал тусгагдаагүй. Даатгалын тохиолдлыг шалгах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, зам тээврийн ослын улмаас бусдын эд хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд тээврийн хэрэгслийг шууд засварын газарт шилжүүлдэг байх шаардлагатай гэдгийг анхаарч үзээгүй байна.	Саналыг хэсэгчлэн тусгав. Жолоочийн даатгалын тохиолдлыг цахимаар ослыг тодорхойлох боломжтой болж байгаа тухай, талууд харилцан тохиролцсоноор засварын газраар засуулах сонголттой болгон найруулсан.
		Тээврийн хэрэгслийн өмчлөгч хариуцлагын даатгалын гэрээ хийсэн бол жолоочийн тоог хязгаарлахгүй буюу тухайн	Саналыг тусгав. Итгэлцүүрт жолоочийн тоо хязгаарлахыг

17.	тээврийн хэрэгслийг өмчлөгчөөс өөр хүн жолоодож замын хөдөлгөөнд оролцож байхдаа зам тээврийн осол гаргасан бол бусдад учруулсан хохирлыг даатгалаас нөхөн төлдөг байх зохицуулалтыг тусгах шаардлагатай байгааг анхаараагүй орхигдуулсан байна.	хассан боловч өмчлөгчөөс бусад жолоочийн учруулсан хохирлыг даатгагч, Холбоо хариуцах тухай заалтыг хуулийн төслийн 7.1-д “Автотээврийн хэрэгслийн өмчлөгч нь автотээврийн хэрэгслийн эзэмшигчийн зам болон авто зогсоол дээрх хөдөлгөөнд оролцох үедээ” гэж өөрчлөн найруулав.
18.	Жолоочийн даатгалын тухай хуулийн төсөлд даатгалын хураамж, үнэлгээ нарийвчлан зохицуулаагүй, даатгуулагчдын эсрэг Даатгалын компаниуд ашиг олоход чиглэгдсэн зүйл, заалтуудыг хуулийн төсөлд тусгасан. Даатгалын суурь хураамжийг хуулиар тогтоох шаардлагатай бөгөөд харин хураамжийг тооцох итгэлцүүрийг боловсронгуй болгох ёстой байсан боловч өнөөгийн мөрдөгдөж буй хуулийн 10, 11 дүгээр зүйлийг хасаж, Санхүүгийн зохицуулах хороонд эрх мэдлийг өгсөн байна. Хуулийн төслийг судлан үзэхэд Санхүүгийн зохицуулах хороо хэт их эрх мэдлийг өөр дээрээ төвлөрүүлсэн байгааг цаашид анхаарах;	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Уг хуулийн төслийн 9 болон 10-р зүйлд жолоочийн даатгалын хураамж, үнэлгээг нарийвчлан тусгав. Хуулийн төслийн 4.1.5-д “жолоочийн даатгалын үйл ажиллагааны зардлыг боломжит хамгийн бага түвшинд байлгах” гэж зарчмыг тусган оруулсан. Мөн олон улсын туршлагыг судлан үзэхэд хуульд суурь хураамжийг тусгадаггүй байна.
19.	Жолоочийн даатгалын тухай хуулийн төсөлд даатгалын үнэлгээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-40 дахин нэмэгдүүлэн тооцох заалт тусгагдсан. Энэ нь зам тээврийн ослын гаралтыг дэмжсэн, жолоочийг хариуцлагажуулахын эсрэг зохицуулалт болсон байна. Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш өнгөрсөн 11 жилийн хугацаанд олгосон зам тээврийн ослын нөхөн төлбөрийн 15 орчим нь 5-10 сая төгрөгийн хооронд, үлдсэн 85 хувь нь 5 сая төгрөгөөс доош төгрөгийн хохирол нөхүүлсэн байна. Даатгалын судалгаагаар үнэлгээг өндөр хэмжээтэй болгож байгаа нь даатгалын хураамжийн хэмжээ өсөх, даатгуулагчийн төлөх хураамж нэмэгдэх, улмаар даатгуулахаас зайлсхийх сөрөг нөлөөтэй талаар шинжлэн судлаагүй, зөвхөн даатгалын	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Жолоочийн даатгалын үнэлгээний хэмжээг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага урган гарсан тухай батлагдсан хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан бөгөөд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулсан олон улсын жишиг байдаг байна.

		компаниудад ашиг олох арга замыг бүрдүүлж байгаагаараа учир дутагдалтай байна.	
20.		Судалгаагаар нийт даатгуулагчдын 95 орчим хувь нь даатгалын тохиолдол гаргаагүй боловч дараа жилд нь ямар ч хөнгөлөлт үйлчилгээ авах эрхгүйгээр давтан хураамж төлсөөр байгаа нь албан журмын даатгалыг албан татвараас ялгарахгүй агуулгатай болгож байгааг хуулийн төсөлд анхаарч үзээгүй байна.	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн 11.1.2-т заасан “өмнөх гэрээний хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээ” гэж байгаа заалт нь даатгалын тохиолдол гаргаагүй жолооч нарын дараа жилийн хураамжид хөнгөлөлт үзүүлдэг бөгөөд олон улсад өргөн хэрэглэгддэг “Бонус-малус систем” юм. Энэхүү зарчим нь шинэчилсэн найруулгын төсөлд мөн хэвээр хадгалагдаж байгаа болно.
21.		Хүчин төгөлдөр мөрдөж буй Жолоочийн даатгалын тухай хуулийн 21, 22, 23 дугаар зүйлийг хэрэгжүүлж, төвлөрсөн хөрөнгийг төрийн бус байгууллага буюу Заавал даатгалын холбооны хөрөнгө байхаар хуульчилсан байна. Гэтэл хуулийн 23.2-д “Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг энэ хуулийн 23.1-д зааснаас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно” гэсэн заалтыг шууд хассан шалтгаан нь ойлгомжгүй байна. Энэ хөрөнгийг Заавал даатгал холбоо, даатгалын байгууллагуудын дундын холбоо зэрэг төрийн бус байгууллагууд ашиглахаар хуулийн төсөлд тусгасан байна. Төрийн бус байгууллагын үүрэг, чиглэл нь Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулагдах харилцаа тул хуульд нийцүүлэх.	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Даатгалын тухай хуулийн 65 дугаар зүйлд заасан Заавал даатгалын холбоо нь хуулийн төслийн 65.2-т заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд сангийн хөрөнгийг зарцуулах бөгөөд уг Холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хороо болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг оролцуулан Хороо батлахаар тусгав.

22.		Албан журмын даатгалыг хэрэгжүүлэх зарчим ашгийн бус байхаас гадна даатгуулагчдын төлсөн хураамж даатгуулагчдын эрх ашигт зориулагдах учиртай байхад манай улсад яагаад ашиг олох арга хэрэгсэл болгон учир шалтгааныг цаашид судалж үзэх нь зүйтэй.	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Хуулийн төслийн 4.1.5-д “жолоочийн даатгалын үйл ажиллагааны зардлыг боломжит хамгийн бага түвшинд байлгах” гэж тусгасан бөгөөд 2023 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгагчдын хосолсон харьцаа 109.8 хувьтай байгаа нь уг даатгалаас ашиггүй ажиллаж байгааг харуулж байна.
23.		Хуулийн төслийн батлагдсан үзэл баримтлалд тусгагдаагүй асуудлыг хуулийн төслүүдэд тусгасан байгаа нь хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулна” гэж заасантай нийцэхгүй байх тул тандан судалгаа, батлагдсан үзэл баримтлал, хуулийн төслийг уялдуулж, олон нийтийг хамарсан хэлэлцүүлэг зохион байгуулах шаардлагатай байна.	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Хуулийн төслийн үзэл баримтлалын дагуу төслийг боловсруулсан бөгөөд цахимаар болон танхимаар нийт 3 удаагийн олон нийтийг хамарсан хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох саналуудыг төслүүдэд тусгаж ажиллав.
24.	Барилга, Хот Байгуулалтын Яам	Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын 3.3.6-д “тухайн хуулийн зохицуулалтад хамаарахгүй, агуулгатай нь нийцээгүй асуудлаар бусад хуульд тусгасныг дуурайх зорилгоор хуулийн төсөлд зарчим заахгүй байхыг анхаарвал зохино” гэж заасан. Гэтэл Жолоочийн даатгалын тухай хуулийн төслийн 4.1.3-т “жолоочийн даатгалд даатгуулаагүй этгээдийн автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх” гэсэн зарчим нь уг хуулийн төслийн зорилго, зохицуулах харилцаанд хамаарахгүй, харин Автотээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулагдах тул уг хуулийн төслийн заалтыг хасаж холбогдох хуульд нэмэлт оруулах замаар шийдвэрлэх;	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Хуулийн төслийн 4.1.3-д заасан уг зарчим нь тус хуулийн төслийн үндсэн суурь зарчим болгон тусгасан заалт болгосон бөгөөд олон улсын туршлагаас авч үзэхэд жолоочийн даатгуулаагүй жолоочийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх зарчим мөрдүүлдэг байна.

25.		Жолоочийн даатгалын тухай хуулийн төслийн 4.1.1-д “автотээврийн хэрэгслийн өмчлөгч нь жолоочийн даатгалд заавал хамрагдах” гэж заасны “... өмчлөгч” гэсэн нь Зөрчлийн тухай хуулийн 11.15 дугаар зүйлийн 7-д “Жолооч нь жолоочийн даатгалд даатгуулалгүйгээр тээврийн хэрэгслээ ашиглан замын хөдөлгөөнд оролцсон бол ... торгоно” гэж заасны “жолооч” гэсэнтэй нийцэхгүй байх тул уг заалтыг дахин авч үзэх.	Саналыг тусгав. Хуулийн төслийн батлагдсан үзэл баримтлалд тухайн авто тээврийн хэрэгслийн өмчлөгч нь заавал даатгуулах үүрэгтэй байхаар тусгасан бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 11.15 дугаар зүйлийн 6 болон 7-д заасан “жолооч” гэдгийг “авто тээврийн хэрэгслийн өмчлөгч” гэж өөрчлөхөөр дагалдах төсөлд тусгав.
26.	Эдийн засгийн хөгжлийн яам	Хуулийн төсөлд тусгасан зохицуулалтууд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасан “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл хуулийн нийт заалтын 50-с дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол, тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон ...” гэсэн шаардлага хангагдаагүй байх тул хуулийг төслийг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар танилцуулж батлуулах нь зүйтэй байна.	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Уг хуулийн төсөлд нийгмийн харилцааны томоохон өөрчлөлтүүд гарч байгаа болон нийт заалтын 50-с дээш хувьд өөрчлөлт орж байгаа. Тухайлбал Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд заалтуудын 37%-д өөрчлөлт, 31% нь шинээр, Даатгалын зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн заалтуудын 33%-д өөрчлөлт, 38% нь шинээр, Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн заалтуудын 40%-д өөрчлөлт, 22% нь шинээр тус тус нэмэгдэж өөрчлөлтүүд туссан болно.
27.		Төслийн 3.1.8-ын “Санхүүгийн зохицуулах хороо” гэснийг “Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/” гэж өөрчлөх;	Саналыг тусгав. Хуулийн төслийн 7.4-т тусгав.

28.		Төслийн 5.3-д “тээврийн хэрэгслийн өмчлөгч” гэсний дараа “энэ хуулийн 6.1-д зааснаас бусад тохиолдолд заавал даатгуулна” гэж нэмэх;	Саналыг тусгав.
29.		Төслийн 16.1-д заасан “аль боломжтойд нь” гэснийг илүү тодорхой болгон өөрчлөн найруулах;	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Даатгалын тохиолдол гаргасан жолооч зугтаасан бол түүний хохирогч нь өөрөө даатгалтай байсан эсэх, мөн хүний амь нас, эрүүл мэндийн хохирол учирсан зэргээс хамаарч даатгагч, цагдаагийн байгууллага, Холбооны аль нэгэнд мэдэгдэх боломжтой, нөгөө талаас хүндрэлтэй нөхцөлд аль нэгд мэдэгдсэн байхаар тусгав.
30.		Төслийн 20.2-ыг “Даатгагч, холбоо нь даатгуулагчийн гэм буруу нь тогтоогдсон тохиолдолд эд хөрөнгөнд учирсан хохиролд харгалзах нөхөн төлбөрийн хэмжээг энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу ажлын 10 өдрийн дотор хохирогч талд олгоно.” гэж өөрчлөн найруулах;	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгад хохирогчийн амь нас, эрүүл мэндийн хохирол болон эд хөрөнгийн хохирол нь заагтай тусдаа болж зохицуулсан учир “эд хөрөнгөд учирсан хохиролд харгалзах нөхөн төлбөрийн хэмжээг ...” гэж өөрчлөн найруулах шаардлагагүй болно
31.		“Монгол улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан хавсралтын 45-д Жолоочийн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулахаар заасан ба уг хуулийн төсөлд авто засвар, үйлчилгээ болон эрүүл мэндийн байгууллага оролцох боломжийг бүрдүүлэхээр тусгасныг хуулийн төсөлд тусгаагүй байгааг анхаарах.	Саналыг тусгав. Хуулийн төслийн 20.3-д “Даатгагч, Холбоо нь хохирогчид учирсан хохирлыг барагдуулахдаа даатгуулагч, жолооч, хохирогч нартай тохиролцсоны дагуу даатгалын үнэлгээнд багтаан хөрөнгийг засварын газраар

			засуулахаар, эсхүл хохирогчийг эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхээр тохиролцож болно.” гэж өөрчлөн найруулав.
32.	Хууль зүй, Дотоод хэргийн яам	Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтад нэгээс дээш хохирогчтой тохиолдолд жолоочийн даатгалын үнэлгээний доод хэмжээг тусгайлан тогтоох буюу хохирогчийг багцлах шаардлагатай эсэхийг дахин нягтлах. Учир нь хэдэн хохирогчтой байхаас үл хамаарч хохирогч бүрийн хохирол нөхөн төлөгдөхүйц байх зарчимд нийцэх шаардлагатай.	Саналыг дараах үндэслэлээр тусгах боломжгүй болно. Хуулийн төсөлд нэгээс дээш хохирогчтой амь нас, эрүүл мэндийн хохирлын хувьд жолоочийн даатгалын үнэлгээний доод хэмжээг зааж өгсөн бөгөөд сайн дурын жолоочийн хариуцлагын даатгалаар нэмэгдүүлж даатгуулах боломжтой. Мөн үнэлгээний хэмжээг тодорхой зааж өгснөөр даатгач нар өөрсдийн актуар тооцооллоор өөрсдийн хүлээн авч болзошгүй хариуцлагын хязгаарыг урьдчилан тооцоолон эрсдэлийн үнэлгээ хийдэг учир үнэлгээний хязгаарыг тодорхой зааж өгөх шаардлагатай.
33.		Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Хороо жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, олгохоос татгалзахтай холбоотой журмыг батална” гэж заасан нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасантай зөрчилдөж байх тул зөвшөөрөлтэй холбогдох харилцааг хуулиар зохицуулах.	Саналыг тусгав.

34.		Хуулийн төслийн 17 дугаар зүйлд даатгагч даатгалын гэрээний дуусгавар болох хугацааг тодорхой хугацааны өмнө даатгуулагчид мэдэгдэх үүргийг тусгах .	Саналыг тусгав. Хуулийн төслийн 17.4 заалтад “Даатгагч жолоочийн даатгалын гэрээний хугацаа дуусгавар болохоос 3-с доошгүй өдрийн өмнө даатгуулагчид аль нэг хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй.” гэж өөрчлөн найруулав.
-----	--	--	---

---oOo---